

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 дугаар сарын 21

Дугаар 74

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 2023 оны газар зохион
байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван хоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.

2.Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг дарга (Н.Баярмөнх)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын-ний өдрийн арван хоёрдугаар хуралдааны дүгээр тогтоолын хавсралт

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2023 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ

НЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛУУД

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Төлөвлөгөөнд тусгах үндэслэл
Нэг. Хууль эрх зүйн хүрээнд хийгдэх ажил				
1.	Газрын ерөнхий хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын төлбөрийн хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хууль, Кадастрын тухай хууль зэрэг 5 хуульд өөрчлөлт оруулах, батлуулах асуудлаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагад уламжлах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон дэд бүтцийн болон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаатай холбогдон улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэх, газрын эдийн засгийн үр өгөөж ихээхэн нэмэгдэж байгаа зэрэг шалтгааны улмаас газрын эрхзүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, эрхзүйн шинэтгэл хийх, газрын нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх зэргээр нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Газрын тухай багц хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүссэн;
2.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолын холбогдох хэсэг /Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах/-т өөрчлөлт оруулсан тогтоол шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах	НГЗБА, УСУГ, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан зарим хил нь олон жил суурьшин амьдарч буй иргэдийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газартай давхацсан, зарим хэсэгт тогтоолд авах шаардлагагүй газруудыг хамааруулсан зэргээс шалтгаалан тогтоолын хэрэгжилтийг хангах, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл учирч, Монгол Улсын Усны тухай хуулийн 22 дугаар зүйл дэх заалтууд бүрэн хэрэгжиж чадахгүй байгаа тул тогтоолыг өөрчлөх шаардлагатай болсон;

3.	Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/39 дүгээр тогтоолын дагуу газрын үнэлгээний итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг шинэчлэх, дүгнэх, хэрэгжилтийг зохион байгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоол.
4.	Тусгай хамгаалалттай газар нутаг /Богдхан уул/, түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх асуудлын хүрээнд холбогдох төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах, санал хүргүүлэх	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба	I-IV улиралд	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 6.1 дэх заалт.
Хоёр. Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил				
5.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө”, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.1 дэх заалт;
6.	Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, холбогдох шийдвэрийг гаргуулан бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Зорилт 2.5, 9.2 дах заалт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.1 дэх заалт;
7.	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод болгох, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах “Газрын бирж”-ийн цахим систем www.mle.mn/ -ийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 23.2.7 “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах” дах заалт; Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 152 дугаар тогтоол;
8.	Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулсантайгаар холбогдуулан хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.3.2 дах заалт; Хаягийн мэдээллийн систем Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоол
9.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, мод үржүүлгийн зориулалтаар эзэмших газрын байршил, хэмжээг тогтоох.	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай 58 дугаар зарлигийн хүрээнд Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2021 оны 03 дугаар зөвлөмж, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамж.
Гурав. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил				

Хот байгуулалтын чиглэлээр:				
10.	Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын зөрчлийг арилгаж, газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	НГЗБА, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль,
11.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	“Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, ЗТБХБСайдын 2010 оны 418 дугаар тушаал;
12.	Авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барих ажлыг иргэн, хуулийн этгээдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 175 дугаар тогтоол;
13.	Орон сууцны хороолол дундах автомашины гараашуудыг буулган газрыг чөлөөлж, чөлөөлөгдсөн газарт олон нийтэд зориулсан ногоон байгууламж, тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийх боломжийг бүрдүүлэн нийтийн эдэлбэр газраар бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4 дэх заалт;
14.	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд барилгын норм дүрэм зөрчиж газар эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэрийг дүүргийн Засаг даргын захирамжаар цуцлах, тухайн байршилд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан тохижилт, ногоон байгууламж, биеийн тампын талбайг байгуулах ажлыг зохион байгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 61.1 “Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/- ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно” дэх заалт;
Газар зохион байгуулалтын чиглэлээр:				
15.	Нийслэл болон дүүрэг /Налайх дүүрэг, Баянзүрх дүүрэг/-ийн хилийн цэс дамнуулан олгосон маргааныг холбогдох дээд шатны байгууллагуудаар шийдвэрлүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах, батлагдсан Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба	I-IV улиралд	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, УИХ-ын 1996 оны 24 дүгээр тогтоол;
16.	Газрыг улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох асуудлыг Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах, холбогдох байгууллагад саналыг хүргүүлэх	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 16.2 “Аймаг, нийслэл, сум, дүүрэг энэ хуулийн 16.1.1, 16.1.6, 16.1.7, 16.1.11-д заасан зориулалтаар өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно” дах заалт; Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоол;
17.	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутаг түүний хамгаалалтын бүс, хил заагийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх, хяналт тавих	НГЗБА, ДИТХ БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоол;
18.	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нь хүчингүй болж, төрийн мэдэлд шилжсэн газруудыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн дуудлага худалдааны болон Газар зохион байгуулалтын тусгах	НГЗБА,	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 33.1.2 “Энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт

	зарчмаар газар эзэмших, ашиглах эрх олгох ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах	БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба		гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ” дах заалт;
19.	Иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрөлгүйгээр ашиглаж буй илүү талбайн нь бусдын газар эзэмшилтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихөөргүй, нийслэлийн газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үе шатны төсөл, газар ашиглалтын бүсчлэлтэй уялдаж байгаа тохиолдолд ашиглаж буй илүү талбайн хэмжээг нэмж эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар шийдвэрлэх, болон газрын давхардлыг арилгах ажлыг зохион байгуулах.	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 33.1.2 “Энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ” дах заалт;
20.	Улс, нийслэлийн төсөв, гадаадын эзэл тусламжаар хийгдэх улсын болон орон нутгийн чанартай авто зам, явган хүний зам, инженерийн шугам сүлжээний трасс болон нийгмийн хангамжийн барилга, байгууламж, сургууль, цэцэрлэгийн барилга барих газрын байршлын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн газрыг нөхөх олговортойгоор чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах, нөхөх олговрын хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.3 дах заалт;
21.	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамрагдсан газар нутгийн судалгааг гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал бэлтгэн, холбогдох шийдвэрийг гаргуулах	НГЗБА, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.7 “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” дах заалт;
22.	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах	НГЗБА, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.6 “Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна” дах заалт;
23.	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах, тайланг хүргүүлэх	НГЗБА, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 23.2.10 “газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих,” 23.2.21 “газрын төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, чанарын өөрчлөлтийг улсын хэмжээнд хянан дүгнэх үүрэг бүхий хяналт шинжилгээ /мониторинг/-ний сүлжээ ажиллуулах;”
Дөрөв. Газар өмчлөлийн чиглэлээр хийгдэх ажил				
24.	Газар өмчилсөн иргэдийн шийдвэрийн төсөл бэлтгэх ажлын хэсгийн хурлаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, кадастрын зурагт өөрчлөлт оруулах асуудлыг тухай бүрт нь хэлэлцэж шийдвэрлэх	НЗДТГ, НГЗБА, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах

25.	Улаанбаатар хотын ногоон бүс буюу зуслангийн амнуудад газар эзэмшиж байгаа иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 101, 181 дүгээр тогтоол, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу
26.	Газар өмчлөх иргэдийн санал, хүсэлтийг цахим системээр хүлээн авах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэх	НГЗБА, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол
Тав. Газрын кадастрын чиглэлээр хийгдэх ажил				
27.	Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Газар эзэмших ашиглах эрхийг хянан шийдвэрлэх зөвлөлийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ, байршилд өөрчлөлт оруулах, дүйцүүлэн олгох, хэлбэр өөрчлөх, хугацааг сунгах, газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох асуудлуудыг тухай бүрт нь хэлэлцэж шийдвэрлэх	БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/110 дугаар захирамж, Албан даргын 2022 оны А/76 дугаар тушаал
28.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны даргын тушаалаар байгуулагдсан Газрын кадастрын мэдээллийн санд хяналт тавих ажлын хэсгийн хуралаар иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын байршлын кадастрын зургийг шинээр бүртгэх, талбайн хэмжээ, хэлбэр өөрчлөх, устгах, сэргээх, устгагдсан байршилд шинээр нэгж талбар бүртгэхтэй холбоотой асуудлуудыг тухай бүр хэлэлцэж шийдвэрлэх.	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх,
29.	Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган газар ашиглалтыг сайжруулах, авто зам болон явган хүний зам талбайг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах болон тохижилтын ажил гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын зөрчил арилгах, орчны аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг зохион байгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дах заалт;
30.	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, түргэн үйлчилгээний цэгийн зөвшөөрөл өгсөн эрх бүхий байгууллагад албадан чөлөөлүүлэх санал хүргүүлэх, авто болон явган хүний зам хааж байрлуулсан хашаа, хайс, объектуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлж зөрчлийг арилгах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 56.5 “Зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар чөлөөлөх үүрэгтэй; 57.4. Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна” дэх заалт;

31.	Дүүргийн нутаг дэвсгэрт инженерийн шугам сүлжээ, түүний хамгаалалтын бүс дэх холбогдох судалгааг нэгтгэн гаргах, хангагч байгууллагатай хамтарч ажиллах.	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/653 дугаар захирамж;
32.	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний хүрээнд Газрын тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг зөрчсөн төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалангийн талбайн зориулалтаар эзэмшиж ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн газарт судалгаа хийж зөрчилтэй нэгж талбаруудыг цуцалж төсөл хэрэгжүүлэх байгууллагад эзэмшүүлэн эргэлтийн талбайн ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол
Зургаа. Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил				
33.	Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх;
34.	Иргэн хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем, гар утасны аппликейшнд хөгжүүлэлт хийж газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч хувь хүн, хуулийн этгээдүүд өөрийн газартай холбоотой төрийн үйлчилгээг газрын удирдлагын нэгдсэн цахим системийг ашиглаж хүсэлт гаргах, хамааралтай мэдээ мэдээллийг зохих журмын дагуу түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх.	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Засгийн Газрын 2020 оны 110 дугаар тогтоол;
35.	Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын орон зайн мэдээллийг бүрдүүлж, газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд оруулах.	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Засгийн Газрын 2017 оны 289 дугаар тогтоол;
36.	Баянзүрх дүүрэг дэх газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажил болон газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах.	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх;
Долоо. Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэлээр хийгдэх ажил				
37.	Газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмшигч, ашиглагч нарын бүртгэлийн алдаагүй, үндсэн нэгж талбарын газрын төлбөрийн ногдуулалт, нөхэмжлэхийг үүсгэх ажлыг зохион байгуулах	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1, 2-р алба	I-IV улиралд	Засгийн Газрын 2018 оны 182 дугаар тогтоол

ХОЁР. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТОО, ХЭМЖЭЭ

2.1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээг тогтоох							
д/д	Хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Иргэдийн тоо	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
0	1	2	3	4	5	6	7
1.	2	Их Дарь-эх	Гэр бүлийн хэрэгцээ	0.81	13	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
2.	8	Улаанхуаран, Эрдэнэтолгой, Холбоо толгойн гудамж		0.88	13	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
3.	9	Шархад		0.53	8	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
4.	10	Витсамо, Улаанхуаран, Амгалан, Төмөр зам, Хангамжийн гудамж		6.4	108	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
5.	11	Товчоо, Туул, Эмийн ургамал, Хөлийн гол, Дэнж, Баянбулаг, Баянзүрх, Усан сан, Ургах наран		31.4	508	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
6.		Сүүл даваа, Нам даваа, Дунд даваа, Налайхын пост		88.4	1459	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
7.		Булгачин, Хонхор нуур		93.48	1558	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
8.	12	Сармисны хонхор, Жанжин, Чулуут, Төмөр зам		1.22	20	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
9.	13	Дүүрэг		0.3	8	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
10.	17	Ногоочин, Эрдэнэтолгой, Эмнэлэг		0.78	14	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
11.	19	Цайз, Жаргалант, Дэнж		1.32	21	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
12.	20	Гялалзах, Сүүл даваа		21.74	368	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
13.		Энгэр шанд		46.8	781	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
14.		Майхан уулын ард		81.47	1355	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
15.		Хар усан тохой		16.6	272	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
16.		Бага ам		1.8	31	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
17.		Могойт дэнж, Бага хуандай, Дээндий, Өлийн даваа		37.36	587	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба

18.		Их хуандай ам		100.7	1679	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
19.		Могойт дэнж, Хар хошуу, Арцат, Цэмбэл		123.72	2060	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
20.	21	Ганцын худгийн задгай /Хорих ангийн хамгаалалтын бүсэд орсон айл/		57.5	1150	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
21.		Бага дарь-Эх		5.74	95	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
22.	22	Өлгийн гудамж		0.05	1	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
23.	23	Улиастай, Сургууль		0.7	34	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
24.	24	Цахлай, Овоот Жаргалант, Хоршооллын гудамж, Газарчин		5.62	107	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
25.	25	Олзвойн гудамж		0.05	1	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
26.	27	Жамсран уулын ар, өвөр гудамж		8.17	133	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
27.	28	Хужирбулан		2.8	48	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
28.	29	Сэлбэ гудамж		0.7	10	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
29.	30	Цэргийн хотхон гудамж		1.11	18	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
30.	31	Монелийн гудамж		3.8	76	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
31.	32	Баруун алтан өлгий, Зүүн алтан өлгий, Бунханы		1.94	32	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
32.	33	Их ам, Шар хоолой		163.3	2573	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
33.		Төвийн хэсэг, Их ам, Гачуурмаа		5.32	84	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
34.		Булагийн ам,		39.9	602	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
35.		Шивэртийн ам, Дунд төгөл		60.75	921	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
36.		Бага шар хоолой,		23.3	350	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
37.		Гээпилийн ам, Дархитын ам		48.7	733	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
38.		Баяндөхөм, Гүнжийн хоолой		130.97	1871	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба

39.	34	Ээж хайрхан, Цагаан давааны ам, Шар хад, Тоосгоны ар, Үнэгтийн ам, Давсны булаг	14.52	305	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
40.	35	Баатархайрханы 2 дугаар хэсэг	39.5	650	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
41.		Майхантын ам	9.27	151	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
42.		Шарын ам	25.64	402	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
43.		Баянголын ам	38.1	606	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
44.		Хиймтийн ам	13.75	225	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
45.		Богдын даваа, Цагаан давааны ам	28.35	455	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
46.		Хожуултын ам	26.89	434	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
47.	37	Сармисны хонхор, Жанжин, Чулууны овоо АОС	0.26	8	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
48.	38	Улаанхуарангийн гудамж	0.07	1	III-IV улиралд	БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
Нийт			1412.5	22939		

2.2. Өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ

д/д	Хороо	Газрын байршил	Иргэдийн тоо	Газрын хэмжээ /га/	Зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
0	1	2	3	4	5	6	7
1.	10	Хангамж, Шархад, Витсамо, Улаанхуаран, Амгалан, Эмнэлэг, Холбоотолгойн гудамж	49	1.23	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба
2.	11	Дэнж, Эмийн ургамал, Товчоо, Хонхор, Хөх тэнгэр, Булгачин, Баянбулаг, Замчин, Ногоон зoorь, Усан сан, Төмөрзам, Баянзүрх, Хөлийн гол	155	9.29	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба
3.	12	Жанжин, Төмөр замын гудамж	9	0.41	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба
4.	13	Дүүргийн гудамж	1	0.038	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба
5.	14	Консулын гудамж	3	0.056	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба
6.	20	Туул ферм, Гялалзах, Туул, Шархоолой, Улаан эрэгийн гудамж	52	3.22	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба
7.	23	Сургууль, Улиастай, Баатархайрханы гудамж	23	1.11	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба

8.	28	Хужирбулангийн гудамж	93	5.35	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба
9.	37	Чулуутын, Жанжины гудамж	5	0.27	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба
10.	42	Консулын гудамж	1	0.042	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 1-р алба
11.	2	Их Дарь-Эхийн гудамж	14	0.73	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
12.	8	Улаанхуаран, Эрдэнэтолгой, Холбоотолгойн гудамж	6	0.215	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
13.	9	Шархад, Эмнэлэг, Ээж хайрханы гудамж	19	0.754	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
14.	17	Эрдэнэтолгой, Эмнэлэг, Сүрлэн, Шархад, Холбоотолгойн гудамж	17	0.842	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
15.	19	Цайз, Хоршоолол, Цэргийн хотхон, Жаргалант, Дэнжийн гудамж	41	2.383	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
16.	21	Дарь Эх, Жамсран уулын өвөр, Жамсран уулын ар, Цэргийн хотхон	16	0.866	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
17.	22	Баруун, Зүүн Алтан-Өлгийн гудамж	1	0.046	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
18.	24	Цахлай, Хоршоолол, Жаргалант, Газарчин, Овоот Цэргийн хотхон, Жаргалантын гудамж	34	1.538	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
19.	27	Жамсран уулын ар, өвөр, Монел, Дунд Дарь эхийн гудамж	45	2.677	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
20.	29	Сэлбэ	9	0.442	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
21.	30	Цэргийн хотхон, Сансар хотхон, Од Монел	23	1.328	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
22.	31	Монел, Монел уул	38	2.006	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
23.	32	Баруун, Зүүн Алтан-Өлгийн гудамж	15	0.755	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
24.	33	Шархоолой, Төв, Дархит Хадтай, Баяндөхөм гудамж	44	2.789	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
25.	34	Ээжхайрхан, Шархад, Тоосгоны арын гудамж	58	3.393	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
26.	35	Баатархайрхан, Улиастайн, Сургуулийн гудамж	49	3.165	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
27.	38	Эрдэнэтолгойн, Улаанхуарангийн гудамж	2	0.048	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
28.	40	Дандар, ЦИС-ийн гудамж	2	0.135	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба

29.	41	Өлгийн гудамж	1	0.0032	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБ 2-р алба
Нийт			825	45.13			

2.3. Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд

д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
0	1	2	3	4	5	6
1.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	Сайханы 3 дугаар гудамж	Нийгмийн дэд бүтэц	0.1	I-IV улиралд	БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
2.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	Наран 9 дүгээр гудамж	Нийгмийн дэд бүтэц	0.045	I-IV улиралд	БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
3.	Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороо	Шархадны эцэс	Авто бусны эцсийн буудал	0.15	I-IV улиралд	БЗДЗДТГ, БЗДГЗБ 2-р алба
4.	Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо	Цагдаа хотхоны хойно	Хорооны байр	0.1	I-IV улиралд	БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
5.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор нуур	Сургууль	1.0	I-IV улиралд	БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
6.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор нуур	Цэцэрлэг	1.0	I-IV улиралд	БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
7.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор нуур	Эмнэлэг	1.0	I-IV улиралд	БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
8.	Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо	Чулуу овоо АОС хороололын урд талд	Тохижилт цэцэрлэгт хүрээлэн	0.1	I-IV улиралд	БЗДЗДТГ, БЗДГЗБ 1-р алба
